

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ

Дугаар 7 2022 оны 4-р сар

■ ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Салхитын ордын хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд хийсэн Эрсдэлийн үнэлгээний талаар танилцуулж байна. Уурхайн өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хаалтын нөхөн сэргээлтийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй эрсдэлийн хүчин зүйлсийг таньж мэдэх, урьдчилсан арга хэмжээг тодорхойлох нь хаалтын төлөвлөгөө боловсруулах чухал алхам болдог.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ХЭРХЭН АШИГЛАДАГ ВЭ?

Уурхайн удирдлагуудын хувьд эрсдэлийн үнэлгээ хийснээр санхүүгийн нөөц, төсөв хөрөнгийн оновчтой хуваарилалт хийх, шаардлагатай хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх боломжтой болдог.

Хууль тогтоогч нарт хаалтын төлөвлөгөөг хянаж батлахад эрсдэлийн урьдчилсан хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээлэл авах, түүнчлэн газар ашиглалтын зориулалтын дагуу нөхөн сэргээсэн талбайг ашиглах боломжтой эсэхийг үнэлэхэд тусалдаг.

Уурхайн менежерүүдэд нөхөн сэргээлтийн туршилт хийх, нэмэлт судалгаа шинжилгээ болон технологийн шинэчлэлд төсөв хөрөнгө зарцуулах шаардлагатай эсэхийг шийдэх үндэслэл болдог.

Хаалтын төлөвлөгөө боловсруулагч нарт эрсдэлийн үнэлгээний дүнг харгалзан гадаргуу хэлбэршүүлэлт, технологи аргачлалыг шийдэх, эрсдэлийн удирдлага, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөх боломжийг олгодог.

Эрсдэлийн ангиллын дугаар	Эмзэг байдлын төрөлжүүлэлт	Эрсдэлийн тоо
1	Геотехникийн тогтворжилт	24
2	Хөрс	6
3	Газрын доорх ус	2
4	Гадаргын буюу ил ус	4
5	Хаягдлын сан	4
6	Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал	6
7	Хөрөнгө хүч	6
8	Уур амьсгалын өөрчлөлт	6
9	Нийгэм-эдийн засаг	8
10	Уурхайн хаалт	13



Эрдэнэс Силвер Ресурс ХХК-н удирдлагуудад эрсдэлийн үнэлгээний үр дүнг танилцуулах уулзалт

Эрсдэлийн тодорхойлолт

Өнөөгийн эрсдэл Уурхайн талбайн одоогийн нөхцөл байдалд үүсэж болзошгүй эрсдэлүүд, тэдгээрийн үр дагавар ба магадлал.

Үлдэгдэл эрсдэл Санал болгож буй нөхөн сэргээлтийн арга технологи хэрэгжүүлсний дараа үүсэж болзошгүй эрсдэлүүд, үр дагавар ба магадлал.

Нуугдмал эрсдэл Одоо хараахан илрээгүй боловч ирээдүйд үүсэж болзошгүй эрсдэлүүд, тэдгээрийн үр дагавар ба магадлал.

ЭРСДЭЛИЙГ ХЭРХЭН ИЛРҮҮЛЖ, ХЭМЖИХ ВЭ?

Эрсдэлийн үнэлгээ хийхдээ компанийн холбогдох тайлан мэдээллүүд болон орчны хяналт шинжилгээний хүрээнд хийсэн хөрс, усны шинжилгээний дүгнэлтүүд, өмнө тодорхойлж байсан эрсдэлийн хүчин зүйлүүд, эмзэг байдалтай танилцлаа. Тухайлбал, уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд зарим эрсдэлүүдийг дурдсан байв. Мөн уурхайд жил бүрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэдэг хөрс, усны шинжилгээний дүнгүүдээс байгаль орчны өнөөгийн төлөв байдлын талаар мэдээлэл авлаа.

Хаалтын нөхөн сэргээлтийг хийхэд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой нийт 79 эрсдэлийн бүртгэл хийж, эмзэг байдлын 10 ангиллаар төрөлжүүлсэн ба эрсдэл тус бүрийн тайлбар тодорхойлолт боловсруулсан.

ЭРСДЭЛИЙГ ХЭРХЭН ҮНЭЛСЭН ВЭ?

Эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт нь эрсдэлийн тохиолдох магадлал ба үр нөлөөг дүгнэх үндсэн удирдамж болдог. Эрсдэл илрүүлэх, шинжихэд хувь хүний үнэлэмжээр биш асуудалд үндэслэлтэй, бодитой хандахад эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь тусалдаг. Эрсдэлийн үр нөлөө ба магадлалын түвшинг хэмжих шалгуур үзүүлэлтийг доор тайлбарласан таван чиглэлээр боловсруулав.



Салхитын уурхайд хийсэн Эрсдэлийн үнэлгээний арга зүйг танилцуулах уулзалт

ЭРСДЭЛИЙН ТӨРЛҮҮД БА ТЭДГЭЭРИЙГ ОНООГООР ХЭРХЭН ҮНЭЛСЭН ВЭ?

Эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг 1) Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал; II) Хүрээлэн буй орчин; III) Үйл ажиллагааны; IV) Нэр хүндийн; ба V) Санхүү болон эрх зүй гэсэн таван төрлөөр багцлан боловсруулав.

Эрсдэлийн төрөл нь тухайн эрсдэл үүссэн тохиолдолд гарах үр дагаврыг танихад тусална. Эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт нь эрсдэлийг үнэлэх удирдамж болдог бөгөөд эрсдэл тус бүрийн үр нөлөө ба магадлалыг 1-5 оноогоор дүгнэв. Доорх хүснэгтээр жишээ болгон харуулсан 1.9 дугаарлалт бүхий эрсдэлийн хувьд хүн амын эрүүл мэнд ба нэр хүндийн эрсдэл хамгийн өндөр оноотой буюу их эрсдэлтэй байна. Тухайн илрүүлсэн эрсдэлийг 5 төрлөөр хэмжиж ойлгох нь нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөх техникийн багийн гишүүдэд эрсдэлийн удирдлага буюу хариу арга хэмжээг оновчтой төлөвлөхөд нэн тустай.

Эрсдэлийн тодорхойлолт:	ХАЯГДАЛ ОВООЛГОД ГУЛСАЛТ, НУРАЛТ ҮҮСЭХ	Үр нөлөө	Магадлал	Эрсдэлийн төвшний оноо	
Эрсдэлийн төрөл	Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал	5	3	15	Нийт 55
	Байгаль орчны эрсдэл	2	3	6	
	Үйл ажиллагааны эрсдэл	3	3	9	
	Нэр хүндийн эрсдэл	4	4	16	
	Санхүү ба хууль, эрх зүйн эрсдэл	3	3	9	

ЭРСДЭЛИЙН ОНОО ЮУГ ИЛЭРХИЙЛЭХ ВЭ?

Эрсдэлийн матриц нь тодорхойлсон эрсдэл тус бүрийн магадлал ба үр нөлөөг оноогоор үнэлэх систем юм. Уурхайд илэрч болзошгүй эрсдэл нь Үр нөлөө ба Магадлалын үржвэрээр илэрхийлэгдэнэ. Эрсдэлийн матрицын дагуу эрсдэл тус бүрийг хамгийн ихдээ 25 оноогоор үнэлэх бөгөөд онооны нийлбэрийг үндэслэн эрсдэлийн “маш өндөр”, “өндөр”, “дунд” ба “бага” гэсэн аюулын зэрэглэлийн 4 ангилалд хамруулж авч үзэв. Таван төрлийн эрсдэлийн нийлбэр нь эрсдэлийн нийт оноог илэрхийлнэ. Тухайн эрсдэлийн нийлбэр оноог дүгнэж, хамгийн ноцтойгоос бага эрсдэл рүү буурах байдлаар эрэмбэлэв.

		Үр нөлөөний түвшин				
		Маш бага = 1	Бага = 2	Дунд = 3	Өндөр = 4	Маш өндөр = 5
Магадлалын түвшин	Ховор = 1	1	2	3	4	5
	Бага = 2	2	4	6	8	10
	Болзошгүй = 3	3	6	9	12	15
	Өндөр = 4	4	8	12	16	20
	Маш их = 5	5	10	15	20	25

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН САР ТУТМЫН УУЛЗАЛТ

Жишиг төслийн I үе шатны оролцогч талуудын сүүлийн уулзалтыг MERIT нь 2022 оны 4-р сарын 20-нд зохион байгуулав. Энэхүү ээлжит уулзалтын зорилго нь:

- Эрсдэлийн үнэлгээ хийх ач холбогдлыг танилцуулах, эрсдэлийн үнэлгээний аргачлал ба хэрэгжүүлсэн алхмуудын талаар мэдээлэх
- Эрсдэлийн үнэлгээний үр дүнг танилцуулах
- Эрсдэлийн үнэлгээний үр дүнг үндэслэн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах нь урьдчилсан хяналт хийх, нөхөн сэргээлтийн арга оновчтой төлөвлөхөд туслах

Хариу арга хэмжээ	
1 - 6	Бага эрсдэл
7 - 12	Дунд эрсдэл
13 - 19	Ир эрсдэл
20 - 25	Маш өндөр эрсдэл

■ ЖИШИГ ТӨСЛИЙН 1-Р ҮЕ ШАТЫГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭВ

Салхитын ордын хаалтын төлөвлөгөөний туршилтын 1-р үе шат амжилттай хэрэгжиж дууслаа. MERIT төслийн зүгээс идэвхтэй хамтран ажиллаж, хувь нэмрээ оруулсан төслийн зөвлөхүүд, бусад оролцогч нартаа талархаж байна. Мөн төслийн эхний шатны хэрэгжилтэд үнэтэй санал зөвлөмжөө хуваалцаж, сургалт хэлэлцүүлгүүдэд идэвхтэй оролцож, хамтран ажилласан бүх оролцогч талууд, хамтрагч байгууллагуудад гүн талархал илэрхийлэв. Та бүхний оруулсан хувь нэмэр төслийн хэрэгжилтэд ихээхэн үнэ цэнэтэй юм. Тэр дундаа бодлогын түвшинд тууштай дэмжин хамтран ажиллаж буй Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, техникийн түвшинд нягт хамтран ажиллаж буй “Эрдэнэс Силвер Ресурс” компанид онцгойлон талархлаа илэрхийлж байна.

■ ЖИШИГ ТӨСЛИЙН 2-Р ҮЕ ШАТАНД САЛХИТЫН ОРДЫН ХААЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛНА

MERIT төслөөс Салхитын ордын Хаалтын менежментийн төлөвлөгөө боловсруулах 2-р шатны ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргах, холбогдох төсвийг төлөвлөх, батлах зэрэг бэлтгэл ажлуудыг хийгээд байна. Бид 2022 оны 5-р сараас Техникийн багийн бүрэлдэхүүнд ажиллах Үндэсний зөвлөхүүдийг сонгон шалгаруулж гэрээлэх болно. Та бүхэнд жишиг төслийн цаашдын хэрэгжилт, тухайлбал төлөвлөгөө боловсруулах техникийн баг, ажлын нарийвчилсан хуваарь, талуудын оролцооны арга хэлбэрүүдийн талаарх мэдээллийг дараагийн дугааруудаар хүргэх болно.

ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн дэд захирал Р.Алтангэрэл

✉ r.altangerel@merit.mn